



Хувь хүн болон гэр бүлд зориулсан

Шинэ төрлийн Коронавирусын эсрэг тусламжийн карт

※ Тус бүрийн тогтолцоонд мөрдөх/хэрэглэх нөхцөл, шаардлага болон нэмэлт төсөвт цаашид өөрчлөлт орох боломжтойг анхаарна уу. Иймд өөрчлөлтийн талаарх мэдээллийг холбогдох нүүр хуудсаас (QR код) авна уу.

2020 оны 4 сарын 26-ны өдрийн хувилбар

Ашиглах зориулалт бүхий тусламжийн тогтолцооны картаа хайж олно уу.



©2020 Kai NAGANO (lowyer)
Ver. 20200419

Амжиргааны зардал болон орон сууцны төлбөр

Онцгой тохиолдлын бага хэмжээний мөнгөн тусламж (Зээл)



Сургуулийн үйл ажиллагаа зогсох, хувиараа аж ахуй эрхлэх зэрэг
200,000 иэн хүртэл
Бусад тохиолдол
100,000 иэн хүртэл

Харилцах цонх

Нийгмийн халамжийн зөвлөл (мөн нэмэлтээр Хөдөлмөрийн Банк)

Болзол

Шинэ төрлийн Корона вирусн улмаас орлого буурсан, ажилгүй болсон зэргээр амжиргааны хүндрэлтэй тулгарч буй өрх
Хүүгүй/Барьцаагүй/ Зээлийн эргүүлэн төлөлтийг хойшлуулах хугацаа 1 жил/ Зээл төлөх хугацаа 2 жил

Нэгдсэн тусламжийн тэтгэмж (Зээл)



2-с дээш ам бүл бүхий өрх
Дээд тал нь 600,000 иэн хүртэл
Ганц бие өрх
Дээд тал нь 450,000 иэн хүртэл

Харилцах цонх

Нийгмийн халамжийн зөвлөл (мөн нэмэлтээр Хөдөлмөрийн Банк)

Болзол

Шинэ төрлийн Корона вирусн улмаас орлого буурсан, ажилгүй болсон зэргээр амжиргааны хүндрэлтэй тулгарч буй өрх
Хүүгүй/Барьцаагүй/ Зээлийн эргүүлэн төлөлтийг хойшлуулах хугацаа 1 жил/ Зээл төлөх хугацаа 10 жил

Орон байрны тэтгэмж



3 сарын хугацаатай тэнцэх орон сууцны түрээсийн төлбөрийг (ажил хайж байгаа тохиолдолд дээд тал нь 9 сар хүртэлх хэмжээний) түрээслүүлэгч/өмлөгчид шилжүүлэх

Харилцах цонх

Нутгийн өөрөө удирдах байгууллагын Бие даасан байдлыг дэмжих байгууллага

Болзол

Ажилгүй болсон/ Аж ахуй эрхлэхээ больсноос хойш 2 жил өнгөрөөгүй мөн хувийн болон албан байгууллагаас хамаарах шалтгааны улмаас чөлөө авснаас үүдэн орлого бүүрч ажилгүй болсонтой адил түвшний нөхцөл байдалд байгаа хүн
Хэрэглэх нөхцөл шаардлагыг бууруулсан ч хөрөнгө/орлогын нөхцөл, шаардлага байх болно

Хувийн болон албан байгууллагаас хамаарах шалтгааны улмаас чөлөөтэй үе дэх дэмжлэг

Хувийн болон албан байгууллагаас хамаарах шалтгааны улмаас чөлөөтэй үе дэх тэтгэмж



Албан байгууллагын шаардлагын улмаас чөлөө авсан тохиолдолд цалин хөлийн 60% ба түүнээс дээш хэмжээний мөнгөн төлбөр (Хөдөлмөрийн стандартын тухай хууль)

Харилцах цонх

Ажиллаж буй албан байгууллага

Болзол

Тухайн албан байгууллагаас чөлөө авах тухай шаардлагыг хүлээн авсан ажилтан (Цагаар ажиллаж буй тохиолдол мөн адил хамаарна)
Хувийн болон албан байгууллагаас хамаарах шалтгааны улмаас чөлөөтэй үе дэх тэтгэмж хэлбэрээр хөдөлмөрийн харилцааг дахин зохицуулах тэтгэмж авч байгаа

Бага сургууль түр хаагдсаны улмаас хүүхэд чөлөөтэй үе дэх мөнгөн тэтгэмж



Цалинтай ээлжийн амралтаа авсан ажилтанд төлөх цалин хөлийн (Өдөрт дээд хэмжээ нь 8,330 иэн)

Харилцах цонх

Сургууль түр хаагдсан үе дэх мөнгөн тэтгэмжийн талаарх хүсэлт хүлээн авах төв

Болзол

Сургууль түр хаах онцгой шийдвэрийн улмаас хүүхэд харахаар чөлөө авсан асран хамгаалагчийн ажиллаж буй албан байгууллага
Тухайн жилийн цалинтай ээлжийн амралтаас тусдаа цалинтай амралт авсан байх шаардлагатай

Өвчин, гэмтлийн тохиолдолд олгох тэтгэмж (Эрүүл мэндийн даатгал)



Шинэ төрлийн корона вирусн халдварын улмаас ажиллах боломжгүй болсон хугацаа Дундаж өдрийн цалингийн хэмжээний 3-ны 2-тэй тэнцэх хэмжээний цалинг олгоно

Харилцах цонх

Эрүүл мэндийн даатгалын холбоо

Болзол

Шинэ төрлийн корона вирусн халдварын улмаас ажиллахгүй байгаа ажилтан 4 дэх хоногоос эхлэн олгогдоно. Дээд тал 1 жил 6 сартай тэнцэх хэмжээний

Олгогдох мөнгөн болон бусад тэтгэмж

Тогтмол хэмжээний онцгой мөнгөн тэтгэмж (4 сарын 20-ны өдрийн мэдээлэлд үндэслэнэ)



Хүн бүрт 100,000 иэний мөнгөн тэтгэмж. Орлогын хязгаарлалт байхгүй (3 сарын хугацаан дотор хүсэлтээ гаргах шаардлагатай)

Харилцах цонх

Тухайн орон нутаг (хот, дүүрэг, суурин). Хүсэлтийг шуудангаар эсвэл Web-p гаргана

Болзол

Тухайн иргэний иргэншлээс үл хамааран 2020 оны 4 сарын 27-ны өдрийн байдлаар Оршин суугчийн үндсэн бүртгэлд бүргүүлсэн бүхий л хүн
Орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас хүргүүлсэн хүсэлтийн хуудсанд өрхийн тэргүүлэгч холбогдох банкны дансаа бичиж илгээнэ

Нийтийн дэд бүтэц, үйлчилгээг ашигласны төлбөр



Засгийн газар тус оны 3 сарын 19-ны өдөр нийт аймаг, орон нутагт хандаж корона вирусн нөлөөнд өртөж буй иргэдийн нийтийн дэд бүтэц, үйлчилгээг ашигласны төлбөрийг хойшлуулах тухай мэдэгдсэн. Төлбөр төлөхөд хүндрэлтэй байгаа тохиолдолд тухайн төлбөр хариуцсан харилцах цонхтой зөвлөлдөх хэрэгтэй.

Үндэсний тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал



Корона вирусн улмаас нас барах, хүндээр өвдөх, орлого буурах зэрэг эрсдэл үүсэхээр бол даатгалын төлбөрөөс чөлөөлөх боломжтой (Тодорхой орлогын нөхцөл байгаа)
※Цаашид шинээр гарах мэдээлэлд анхаарна уу.

Компани дампуурсны улмаас авч чадаагүй цалинг нөхөн олгох тогтолцоо



Дампуурсан аж ахуй эрхлэгчийн авч чадаагүй цалингийн 80%(хязгаар байгаа) нөхөн олгох тогтолцоо (Хөдөлмөрийн стандартыг хянан шалгах байгууллага)

Амжиргааны зардал хамгаалал



Орлого нь амжиргааны доод түвшний зардлыг баталгаажуулах хэмжээнд хүрэхгүй тохиолдолд амжиргааны зардал, орон байрны зардал, эмчилгээний зардлыг олгох (Орон нутгийн өөрөө удирдах байгууллага)